



**“МОНГОЛЫН ИРГЭНИЙ АГААРЫН ТЭЭВЭР” /МИАТ/ ТӨХК-ИЙН
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.02.15

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

“Монголын иргэний агаарын тээвэр” /МИАТ/ ТӨХК-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Танилцуулга

МИАТ ТӨХК-ийн 2024 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 92,9%-тай байна. /Хүснэгт 1/

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. МИАТ ТӨХК-ийн 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
29	24	1	1	1	2	-	-	92,1%

МИАТ ТӨХК нь 2024 онд 29 арга хэмжээ хэрэгжүүлэхээр Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлан ажилласан байна.

Нийт 29 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 24 арга хэмжээ, 90%-ийн биелэлттэй 1 арга хэмжээ, 70%-ийн биелэлттэй 1 арга хэмжээ, 50%-ийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ, 30%-ийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ, хэрэгжилт дунджаар 92,1%-тай байна.



Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

№	Арга хэмжээний заалт, агуулга	Хүрэх түвшин	Ируулсэн биелэлт	Тасарсан шалтгаан нөхцөл
1	1.3. АНУ-руу шууд хуваарьт нислэг үйлдэх	<p>I улирал: АНУ-ын чиглэлд тогтмол нислэг үйлдэх бэлтгэл ажлыг хангах чиглэлээр ЗТХЯ, ИНЕГ-т байгуулагдсан ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана</p> <p>II улирал: ИНЕГ-аас нислэгийн зөвшөөрөл авсны дараа нислэг үйлдэж эхэлнэ</p>	<p>Засгийн газрын бүтэц шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан шууд нислэг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг Зам, тээврийн сайдын 2024.08.19-ний өдрийн A/171 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан.</p> <p>Ажлын хэсэг нь тайлан, Залруулах үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулж, суурь үнэлгээгээр илэрсэн үл тохирлыг засаж Залруулах Ажлын хэсгийн нэгдсэн төлөвлөгөөг 2024.09.20-ны өдөр баталсан.</p> <p>IASA шалгалт хийгдсний дараагаар ойролцогоор 120 хоног дотор АНУ-ын Тээврийн аюулгүй байдлыг хангах захиргаа (TSA) шууд нислэгийг эхлүүлэх нисэх буудлын аюулгүй байдлын үнэлгээг хийж дээрх байгууллагуудын шалгалт амжилттай үнэлгээг авч зөвлөмжийг АНУ-ын Тээврийн яаманд өгсөн тохиолдолд агаарын тээвэрлэгчид эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл буюу шууд нислэг үйлдэх эрх олгогдох талаар Тээврийн яамны зүгээс тайлбарласан болно.</p> <p>МИАТ ТӨХК нь АНУ-ын чиглэлд тогтмол нислэг үйлдэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд Ирланд Улсын "AerCap" компаниас өргөн биет B787-9 /Dreamliner/ төрлийн 2 шинэ агаарын хөлгийг урт хугацааны турээсээр авахаар гэррэй байгуулсан бөгөөд эхний 787-9 агаарын хөлгөө 2023.08.11-ний өдөр хүлээн авсан бол хоёр дахь 787-9 агаарын хөлгийг 2024.04.25-ны өдөр хүлээн авсан.</p> <p>МИАТ ТӨХК нь АНУ-ын Иргэний нисэхийн газраар Агаарын хөлгийн засвар үйлчилгээний газрыг FAA FAR 145 дүрмээр гэрчилгээжүүлэх аудит шалгалтад 2024 оны 11-р сард амжилттай шалгуулж, тэнцсэн ба ингэснээр тус компани нь АНУ-ын нислэгийн аюулгүй ажиллагаа, техникийн үйл ажиллагааны чанар, стандартыг бүрэн хангасан болно. 70%</p>	Гадаад хүчин зүйл
2	1.5. БНХАУ-ын Эрээн хот руу	I-II улирал: Эрээн хот руу шууд шууд	ЗТХСайдын 2013.07.10-ны өдрийн A/160 дүгээр тушаалаар МИАТ ТӨХК-ийг УБ-Эрээн-УБ	Гадаад хүчин зүйл



	шууд хуваарьт нислэг үйлдэх	хуваарьт нислэг үйлдэх чиглэлээр төлөвлөгөө батлуулж, бэлтгэлийг бүрэн хангана III улирал: 2024 оны 3-р улиралд багтаан нислэг үйлдэж эхэнэ	чиглэлд зорчигч тээврийн хуваарьт нислэг үйлдэх тээвэрлэгчээр томилсон. БНХАУ-ын Эрээн хотын "SAIWUSU" Нисэх онгоцны буудал нь олон улсын нислэг хүлээж авах зөвшөөрөл байхгүй байгаа тул одоогийн байдлаар нислэг үйлдэх боломжгүй хүлээгдэж байна. ЗТХЯ-ны ТНБД-аас БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Эрээн хотын Засаг даргад хандан 2024.03.22-ны өдрийн 03/1224 дүгээр албан бичгээр МИАТ ТӨХК-ийн Эрээн чиглэлийн нислэг үйлдэх хүснэгтийг уламжилж, нислэгийн зөвшөөрөл авахад дэмжлэг үзүүлэх хүснэгтийг хүргүүлсэн хариу хүлээж байна. МУ-ын ГХЯ, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Ардын засгийн газар хоорондын байнгын зөвлөлдөх ажлын хэсгийн 2024.10.15-ны өдрийн VI хуралд ГХЯ-ны ТНБД Монголын тал УБ-Эрээн-УБ чиглэлд шууд нислэг үйлдэж, хоёр улсын иргэдийг ая тухтай, шуурхай зорчих нөхцөлийг бүрдүүлэхийг хүссэн. БНХАУ-ын тал энэ асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэн эргэн хариу өгөх талаар мэдэгдсэн хүлээж байна. 50%	
3	1.6. Карго ачаа, шуудан дамжин өнгөрүүлэх терминалын барилга Чингис хаан ОУНБ-д шинээр барих	I улирал: Карго терминалын барилга баруулах ажлын тендер зарлан шалгаруулна III улирал: Карго терминалын барилгын ажлыг эхлүүлнэ IV улирал: Карго терминалын барьж дуусгана	Карго ачаа, шуудан дамжин өнгөрүүлэх 3601 м ² терминалын барилга Чингис хаан ОУНБ-д барих зураг төсвийн тендерийн сонгон шалгаруулалт 2024.05.13-ны өдөр бүрэн дуусч, тендерт шалгарсан "Эрхэс констракшн" компани зураг төсвийг боловсруулан "НУБИА" ХХК-иар баталгаажуулан, "Барилгын хөгжлийн төв"-өөр батлуулан, барилгын ажлыг эхлүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд "НУБИА" ХХК-ийн зүгээс Чингис хаан ОУНБ-ын агаарын хөлгийн перрон талбайг баруун, зүүн тийш өргөтгөж, нэмэлт зорчигчийн хүзүүч хийхээр төлөвлөж байгаа тул зөвшөөрөл олгохгүй хүлээгдэж байна. 30%	Үдирдлага, зохион байгуулалт
4	1.7. Газрын тусгай үйлчилгээний техник, тоног төхөөрөмж, автомашин	I улирал: Граж баруулах ажлын тендер зарлан шалгаруулна III улирал:	Газрын тусгай үйлчилгээний техник, тоног төхөөрөмж, автомашин байрлуулах 1200 м ² гражийн барилга Чингис хаан ОУНБ-д барих зураг төсвийн тендерийн сонгон шалгаруулалт	Үдирдлага, зохион байгуулалт



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

	байрлуулах гражийн барилга Чингис хаан ОУНБ-д шинээр барих	Гражийн барилгын ажлыг эхлүүлнэ IV улирал: 40 автомашин, техник, тоног төхөөрөмж багтаах гражийн барилгыг барьж дуусган ашиглалтад оруулна	2024.04.12-ны өдөр бүрэн дуусч, тендерт шалгарсан "Онч тэнхлэг" компани зураг төсвийг боловсруулан "НУБИА" ХХК-иар баталгаажуулан, "Барилгын хөгжлийн төв"-өөр батлуулан, барилгын ажлыг эхлүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд "НУБИА" ХХК-ийн зүгээс Чингис хаан ОУНБ- ын агаарын хөлгийн перрон талбайг баруун, зүүн тийш өргөтгэж, нэмэлт зорчигчийн хүзүүч хийхээр төлөвлөж байгаа тул газрын байршилыг өөрчлөх шаардлага тавьж, зөвшөөрөл олгохгүй хүлээгдэж байна. 30%	
5	3.9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнах	I-IV улирал: НТШ-79, ХА-26, ШХА-36, НЭҮХАА-10 нийт 151 удаагийн худалдан авалт зохион байгуулж, 292,2 тэрбум төгрөг зарцуулна	TӨБЗГ-ын 2023.12.21-ний өдрийн 704 дүгээр тогтоолын дагуу МИАТ ТӨХХ-ийн 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Гүйцэтгэх захирлын 2024.01.22-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар батлан хэрэгжүүлн ажиллаж байна. 2024.12.31-ний өдрийн байдлаар НТШ-61, ХА-17 тендер зарлаж, нийт 117 гэрээ байгуулан 57,6 тэрбум төгрөг, НЭҮХАА-8 гэрээгээр 203,8 тэрбум төгрөг, Ерөнхий гэрээний арга буюу цахим дэлгүүрээр дамжуулан 743,5 сая төгрөг, ШХА-10 буюу 116,7 сая төгрөг, шаардлагатай тохиолдолд ШХА-490 буюу 808,8 сая төгрөг, нийт 262,8 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн. 90%	

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа боловсруулж	
5	4	1	-	-	-	94%

Хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээ:

1/ ЗГХ-ний тэмдэглэл. 2023-09-13 №37

VII. "Агаарын тээврийн тухай Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг хэрэгжүүлж, хоёр улсын хооронд хийх хуваарлыг нислэгийг 2024 оны эхний хагас жилд багтаан эхлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод даалгав.

Биелэлт: МИАТ ТӨХХ нь АНУ-ын чиглэлд тогтмол нислэг үйлдэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд Ирланд Улсын "AerCap" компаниас өргөн биет B787-9 /Dreamliner/



төрлийн 2 шинэ агаарын хөлгийг урт хугацааны түрээсээр авахаар гэрээ байгуулсан бөгөөд эхний 787-9 агаарын хөлгөө 2023.08.11-ний өдөр хүлээн авсан бол хоёр дахь 787-9 агаарын хөлгийг 2024.04.25-ны өдөр хүлээн авсан.

МИАТ ТӨХК нь АНУ-ын Иргэний нисэхийн газраар Агаарын хөлгийн засвар үйлчилгээний газрыг FAA FAR 145 дүрмээр гэрчилгээжүүлэх аудит шалгалтад 2024 оны 11-р сард амжилттай шалгуулж тэнцсэн ба ингэснээр тус компани нь АНУ-ын нислэгийн аюулгүй ажиллагаа, техникийн үйл ажиллагааны чанар, стандартыг бүрэн хангасан болно. 70%

2.3. Сайдын тушаалын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
3	3	-	-	-	-	100%

2.4. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
Төсөв/гүйцэтгэл	6	4	2	-	-	-	90,0
хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	6	4	2	-	-	-	90,0
бусад	5	5	-	-	-	-	100,0
Нийт	17	13	4	-	-	-	92,9

2.5. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	хамаа ралгүй	
Нийт	46	30	1	3	-	12	92,9%

Хэрэгжилт хангалгүй:

- 1/ 1.6. Үйл ажиллагаандaa мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт – мэдээлэл шинэчлээгүй. 30%
- 2/3.4. Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ – мэдээлэл дутуу. 30%
- 3/ 3.10. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан – байгууллагын сайтад цонх нээж холбоогүй. 70%



4/3.12. Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл – Мэдээлэл дутуу. 30%

Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

МИАТ ТӨХК нь ХШУДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг ЗТХЯ-ны Гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, хүрэх түвшинг улирал бүрээр төлөвлөн Зам, тээврийн хөгжлийн яамны холбогдох газруудаар хянуулж, батлан ажилласан байна.

2. Хэрэгжилтийн байдал:

- 1) МИАТ ТӨХК-ийн 2024 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, Шилэн дансны хетлэлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 92,9% буюу эхний хагас жилээс 6.6%-аар ессен дүнтэй байна.
- 2) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 29 арга хэмжээнээс 86,2% нь хүрэх түвшиндээ хүрсэн буюу хүрч байгаа, 13,8% нь төлөвлөсөн түвшиндээ хүрээгүй байна.
- 3) МИАТ ТӨХК нь 2024 онд 1,225,100 зорчигч, 12,6 мян.тн ачаа, шуудан тээвэрлэхээр төлөвлөсөн бөгөөд 2024.12.31-ний өдрийн байдлаар олон улсын хуваарьт 11, захиалгат 3 чиглэл, орон нутгийн хуваарьт 8, захиалгат 1 чиглэлд 4218 удаагийн нислэг үйлдэж, 1,155,100 зорчигч, 14,840 тонн ачаа тээвэрлэжээ.
- 4) 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 942 тэрбум төгрөгийн орлого олж, 916 тэрбум төгрөгийн зардал гарган, 23 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, 2024 оны зорилтот түвшинг 76,7%-тай биелүүлсэн байна.
- 5) 2024 онд МИАТ ТӨХК нь Олон Улсын Агаарын Тээврийн Холбоо /IATA/-ны аюулгүй ажиллагааны "IOSA" аудит шалгалт, газрын үйл ажиллагааны аюулгүй байдлын ISAGO аудит шалгалтуудад тус тус амжилттай шалгуулж, олон улсын стандарт, дүрэм, журамд нийцсэн аюулгүй ажиллагатай тээвэрлэгч болохоо дахин баталсан байна. Мөн тасралтгүй 14,140 км хүртэл зайд нислэг үйлдэх хүчин чадалтай, 292 зорчигчийн суудалтай Boeing 787-9 /Dreamliner/, орон нутгийн чиглэлд нислэг үйлдэх 70 хүний суудалтай CRJ-700 маягийн агаарын хөлгийг хүлээн авчээ.

Санал, зөвлөмж

1. "Чингис хаан" ОУНБ-д Карго ачаа, шуудан дамжин өнгөрүүлэх терминалын барилга, газрын тусгай үйлчилгээний техник, тоног төхөөрөмж, автомашин байрлуулах гражийн барилга барих зэрэг бүрэн хэрэгжээгүй ажлуудыг 2025 оны төлөвлөгөөнд тусган удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах;



2. 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг яаралтай батлан З дугаар сард багтаан сонгон шалгаруулалтуудыг зохион байгуулах;
3. АНУ, БНХАУ-ЫН Эрээн хот руу шууд хуваарьт нислэг үйлдэх ажлыг эрчимжүүлэх;
4. Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах, болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын хавсралтаар Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээг 5 хэсгийн 98 нээлттэй мэдээллээс өөрт хамаарах асуудлыг shilen.gov.mn сайтад тайлагнаж ажиллахаар шийдвэрлэсний дагуу тус сайтад бүртгүүлэн холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд нь байршуулах;

ТАНИЛЦСАН:

САЙД

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ИРГЭНИЙ НИСЭХИЙН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

МИАТ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Б.ДЭЛГЭРСАЙХАН

С.БАТБОЛД

Г.БАТБАЯР

Б.МОНХТАМИР

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ОЮУНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:

ХШҮДАГ-ЫН ШИНЖЭЭЧ

Д.БАЯРМАА



**МИАТ ТӨХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДУН**

№	Хяналтад байх арга хэмжээ	2024 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд үнэлсэн арга хэмжээ /Өссөн дунгээр/	Дундаж хувь	Биелэлт /Хувиар/				
					90	70	50	30	0
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	29	29	92.1	24	1	1	2	-
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	5	5	94.0	4	-	1	-	-
3	Сайдын тушаалын биелэлт	3	3	100.0	3	-	-	-	-
4	Шилэн дансны хөтөлбийн үнэлгээ	17	17	92.9	13	-	4	-	-
5	Ил тод байдлын үнэлгээ	46	34	92.9	30	-	1	-	3
Нийт		100	88	92.9	74	1	7	1	5
									- 12